

ЗӨВЛӨЛТИЙН ДИПЛОМАТ АЛБА (1917-1991)

Д.Доржханд¹

Оросын гадаад бодлого, түүнийг хэрэгжүүлэгч дипломат алба олон зууны турш өөрийн тогтвортой шинж чанарыг хадгалсаар ирсэн бөгөөд хэмжээгүй эрхт хаант засаглалыг унагасан 1917 оны 2-р сарын 27-ны (3-р сарын 12) хувьсгал ч тус улсын гадаад бодлогод зарчмын чанартай өөрчлөлт авчирч чадаагүй. Түр засгийн газрын гадаад хэргийн анхны сайд П.Н.Милюков өөрийн дурсамждаа сайдаар томилогдсоны дараах хамгийн гол анхаарлаа хандуулсан ажил нь Антантын улсуудтай явуулж байсан ерөнхий бодлогоо хадгалан үлдэхэд оршиж байсан гэжээ.

Тэрээр дурсамждаа *"Хүмүүс намайг олон жил сурч боловсролгүйгээр Ордны талбай дахь яамны танхимын суудалд бүрэн эрхт эзэн мэт суусан цорын ганц сайд гэж ярьдаг байлаа. Бодохнээ би мөн ажилчдынхаа нэгийг ч халаагүй цорын ганц сайд байлаа"*² гэж бичжээ.

2-р сарын хувьсгалын гэрч болсон Н.П.Карабескийн хэлснээр *"Одоогийн Милюковын Гадаад явдлын яаманд уламжлалт ёс хувьсгалаас илүү хүчтэй байр суурь эзэлж байна. Бүхий л зүйл хэт ёсорхог, хоосон хөндий байсан"*³ гэсэн байна. Хэлбэрийн хувьд сайхан харагдаж байсан тухайн үеийн Оросын дипломат албанд түр засгийн газрыг удирдаж байсан В.Д.Набоков: *"...Түр засгийн газрын оришн байсан хугацаанд манай бүхий л гадаад бодлого яриа хэлэлцээгээр хязгаарлагдаж байлаа"*⁴ гэж дүгнэсэн байна.

Үнэндээ Октябрийн хувьсгал л Оросын гадаад бодлого, дипломат албыг орвонгоор нь өөрчилсөн билээ.

Октябрийн хувьсгалын эхний 10 хоног Америкийн сэтгүүлч зохиолч Жон Ридын дүрсэлснээр дэлхийг донсолгосон төдийгүй Оросын дипломат ажиллагааны тулгуурыг үндсээр нь хөмрүүлсэн юм⁵.

Ийнхүү 1917 оны 11-р сарын 7-нд ялсан Октябрийн хувьсгалын ачаар Зөвлөлтийн дипломат алба бүрэлдэн бий болжээ. Хуучин тооллоор 1917 оны 10-р сарын 25-26-ны хооронд Бүх Оросын Зөвлөлүүдийн Их хурлаас Зөвлөлт улсын гадаад хэрэг эрхлэх байгууллагыг үүсгэн бий болгох шийдвэр гаргажээ. Уг байгууллагыг уламжлалт ёсоор яам

¹ БНХАУ, Өвөр Монголын Их сургуулийн докторант

² П.Н.Милюков. Воспоминания. М., Политиздат, с.480

³ Страна гибнет сегодня. Воспоминания о февральской революции. М., "Книга", 1991, с.167.

⁴ Мөн тэнд, 405-р тал

⁵ И.Г.Усачев, К истории Советской дипломатии (1917-1991гг.), МГИМО, Российская дипломатия в свете мирового и исторического опыта: Ученые записки, Москва 1996, с.13

гэж биш харин “Ардын Комиссарын газар” хэмээн нэрлэхээр тогтсон нь угтаа ард түмнийг төлөөлсөн гэсэн санааг агуулж байв.

Уг байгууллагын тэргүүнээр томилж болох хүмүүсийн тоонд удам дамжсан дипломат болох нилээд боловсрол мэдлэгтэйд тооцогддог Г.В.Чичерины нэр дурдагдаж байжээ. Түүний эцэг В.Н.Чичерин нилээд олон жил Оросын ГЯЯ болон хилийн чанад дахь төлөөлөгчийн газар ажиллаж байсан байна.

Г.В.Чичерин ч 1897 онд Гадаад явдлын яамны архивт ажилд орсноор дипломатын карьераа эхэлсэн боловч нэг их удалгүй хувьсгалын үйл хэрэгт зүтгэх болж, улмаар гадаадад цагаачлан гарахаас аргагүй болжээ. Харамсалтай нь яг тэр үед Г.В.Чичерин Английн шоронд хоригдож байсан тул түүнийг Гадаад хэргийн ардын комиссараар томилох тухай авч хэлэлцэх боломжгүй байсан нь ойлгомжтой.

Тийм ч учраас Гадаад хэргийн ардын комиссараар Я.М.Свердловын санал болгосноор Л.Б.Троцкий (Бронштейн) томилогджээ. Зөвлөлт засгийн газрыг байгуулах тухай асуудал хэлэлцэж байх үед Л.Д.Троцкийн гаргасан хөрөнгөтний нэр томъёо болох “яам”-ыг “Ардын Комиссарын газар” болгох санал дэмжигджээ.

Тэрээр дурсахдаа *“Гадаад Хэргийн Ардын Комиссарын газарт очих нь надад албан үүргээс чөлөөлөгдөж байгаа мэт санагдсан”* гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, тэрээр хувьсгалын удирдагч Лениний нэгэн адил гадаад бодлогын үйл ажиллагааг 2-р зэрэгт тавьж, Зөвлөлт засгийн тэргүүн зорилт бол Октябрийн хувьсгалыг орон даяар дэлгэрүүлэхэд чиглэх ёстой гэж үзэж байв. Тиймээс ч Троцкий *“За хэдэн хувьсгалын тунхаг хуудсуудыг ард түмэнд тараачихаад мухлагаа хаана”*⁶ гэж хошигнож байв.

“Мухлагаа хаана” гэсэн түүний энэ үгийг Зөвлөлтийн төдийгүй гадаадын судлаачид ч Троцкий Зөвлөлтийн дипломат албыг үүсгэн бий болгоход үл тоомсорлон хандаж байсны жишээ болгон дурддаг.

1918 оны 1-р сард Зөвлөлт засгийн газар Г.В.Чичеринийг төрсөн нутагт нь эргүүлэн авчрах оролдлогоо бүтээж тэрбээр эхэндээ Ардын комиссарын орлогчоор ажиллаж байсан бөгөөд мөн оны 5-р сард Троцкийгийн орыг залгасан байна.

Гэвч Зөвлөлтийн шинэ Гадаад явдлын яамны аппарат эхний өдрөөсөө эхлэн бэрхшээлтэй асуудалтай тулгарчээ. Учир нь хаант засгийн хуучин дипломатууд Зөвлөлт засагтай хамтран ажиллахаас эрс татгалзжээ.

Оросын дипломат Ю.Я.Соловьевын дурссанаар *“Олон тооны Элчин сайдын яам, консулын болон төлөөлөгчийн газар яамны албан хаагчдын жишээг дагасан... Ихэнх оронд, тэр ч бүү хэл холбоотон биш орнуудад байсан Оросын дипломат корпус Зөвлөлт Оросын бодлогод дайсагнагчдын гар хөл болж байв”*⁷.

Тиймээс Гадаад хэргийн ардын комиссарын газарт дипломат туршлагагүй ч зохих боловсролтой, хувьсгалд идэвхийлэн оролцож байсан хүмүүсийг авч ажиллуулахаас аргагүйд хүрсэн байна. Зөвлөлт засгийн эхний жилүүдийн дипломатын түүхэнд нэлээд нэрд гарсан хүмүүсийн тоонд Ардын Комиссарын орлогчоор ажиллаж байгаад Г.В.Чичерины оронд Ардын комиссараар томилогдсон М.М.Литвинов (Макс Валлах), мөн В.В.Воровский, Я.А.Берзин, И.А.Залкинд, А.А.Иоффе, П.Л.Войков, И.О.Коломийцев,

⁶ Л.Троцкий, *Моя жизнь*, Москва 1990, с.64

⁷ Ю.Я.Соловьев, *Воспоминания*, Москва 1959, с.361

Л.Б.Красин, Л.К.Мартенс, В.Р.Менжинский, А.И.Коллонтай, Л.М.Карахан (Караханян), Н.П.Кодчановский, И.И.Майский (Ляховецкий), В.П.Потемкин, Д.З.Мануильский нарыг дурдаж болно⁸.

Зөвлөлтийн Гадаад хэргийн ардын комиссарын газрын төв аппарат маш хурдан бүрэлдэн бий болсон. 1917 оны 12-р сарын 13 гэхэд нийт 126 албан хаагчтай болсон байв. Удирдах албыг мэргэжлийн хувьсгалчид, дунд шатны албан хаагчдыг Зөвлөлт засгийг дэмжигч жирийн сэхээтнүүд, харин доод шатны ажилтнуудыг (нууц түлхүүр тайлагч, хамгаалалтынхан гэх мэт) усан цэргүүд хувьсгалч ажилчид бүрдүүлж байв⁹.

Гадаад хэргийн ардын комиссарын газар тун удалгүй анх үүсэн бий болж байхдаа тулгарч байсан боловсон хүчний бэрхшээлээ даван туулж, аажим аажмаар дипломат албанд бэлтгэгдсэн түүхч, эрх зүйч, эдийн засагч гэх мэт мэргэжлийн хүмүүсээр эгнээгээ бэхжүүлжээ. Үүнд Гадаад хэргийн ардын комиссарын газрын дэргэдэх дипломат болон консулын ажилтныг бэлтгэх сургууль маш их хувь нэмэр оруулсан байна.

Боловсон хүчнийг сонгон авах нэг гол шалгуур бол тухайн хүн заавал коммунист намын гишүүн байх ёстой байжээ. Бүр тэр үед Зөвлөлт засгийн дотоод болон гадаад бодлогын чухал асуудлыг ЗХУКН-ын Төв Хороо болон Улс төрийн товчоо хэлэлцэн шийдвэрлэх зарчим тогтсон байв.

Энэ үед Зөвлөлтийн Гадаад хэргийн ардын комиссарын газрын гол зорилт бол дотоод улс төрийн асуудлыг амжилттай шийдвэрлэхийн тулд Орос улсыг дайнаас гаргах, мөн хаант засгийн нууц гэрээ хэлэлцээрийг нийтлэхэд чиглэгдэж байв. Нууц гэрээ хэлэлцээрийг нийтлэх нь хувьсгалын үйл хэргийг дэлхий даяар түгээн дэлгэрүүлэх, бусад орны ажилчид, цэргүүдийн хүчийг империалист төр засгийн эсрэг босгоход чиглэгдэж байв.

Нийтдээ 130 гаруй нууц баримт бичгийг олж нийтлүүлсэн байна. Үүнд:

- Египет ба Марокког хуваах тухай 1904 оны Англи-Францын хэлэлцээр
- Иран, Афганистаныг хуваах тухай 1907 оны Орос-Английн хэлэлцээр
- II Николай хааны захидлууд
- Нууц дипломат захидлууд
- АНУ, Англи, Францын Элчин сайдын яамдын 1917 оны Орост явуулсан үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүд зэрэг Оросын ард түмний ар хударгаар явуулж байсан нууц дипломат ажиллагаатай холбоотой олон тооны баримт бичгүүд багтаж байв.

Тэрчлэн Гадаад хэргийн ардын комиссарын газрын харьяанд Олон улсын хувьсгалт ухуулгын товчоо байгуулан ажиллуулж байсан нь Октябрийн хувьсгалыг дэлхий даяар түгээн дэлгэрүүлэхийг хүсэж байсан Зөвлөлтийн удирдлагын авч явуулж байсан бодлогын илрэл юм. Америкийн сэтгүүлч Жон Рид энэхүү товчооны гишүүнээр 2 сар ажилласан тухай 1917 оны 2-р сарын 21-нд сенатор Овермены комиссын өмнө тайлбарласан байдаг. Тэрээр *“Бид сонин хэвлэлийн асуудлаар хамтран ажиллаж байв. Миний үүрэг бол Зөвлөлт засгийн гаргасан тогтоолуудын англи хэлээрх орчуулгыг хянах явдал байв. Үүний зэрэгцээ*

⁸ О.П.Селянинов, *Тетради по истории дипломатической службы государств (Возникновение и развитие)*, Москва 1995, с. 131

⁹ И.Г.Усачев, *К истории Советской дипломатии (1917-1991гг.)*, МГИМО, Российская дипломатия в свете мирового и исторического опыта: Ученые записки, Москва 1996, с.25

би герман цэргүүдэд илгээх уран зохиолын номыг цуглуулах, түгээх ажилд оролцож байсан” хэмээн мэдэгдсэн байдаг¹⁰.

Гадаад хэргийн ардын комиссарын газрын хаант засгийн үеийн нууц гэрээ хэлэлцээрийг нийтлэх ажил Зөвлөлтийн дипломат ажиллагааны суртал ухуулга-мэдээлэлд илүүтэй анхаардаг онцлог чанарын эх үндэс болсон. Хүн амын боловсролын түвшин харьцангуй доогуур байсан тэр үед шинэ засгийн гадаад бодлогыг ард түмэнд ойлгомжтой тайлбарлан ойлгуулахыг шаардаж байв. Тиймээс ч Зөвлөлтийн дипломат баримт бичгүүд нэлээд дэлгэрэнгүй, том хэмжээтэй байх болсон бөгөөд түүнийг нь Өрнөдөд тэр бүр сайнаар хүлээн авдаггүй байв.

1990-ээд он хүртэл Зөвлөлтийн түүхчид Зөвлөлтийн дипломат албыг тогтвортой байдал, зарчимч байдлын илэрхийлэл хэмээн үздэг байсан. Зөвлөлтийн дипломат албаны удирдагчдын нэг Г.В.Чичерин 1924 онд бичсэн Лениний тухай дурсамждаа “Зөвлөлт Холбоот улс маш сайн боловсруулсан гадаад бодлогын тогтолцоотой гэдэг нь анхнаасаа л бүхэнд илэрхий байсан”¹¹ хэмээн нотлосон байдаг. Гэхдээ энэхүү тогтолцоо нь мэдээж Лениний толгойд боловсрогдсон гэдгийг тэрээр хүлээн зөвшөөрсөн.

Зөвлөлтийн түүх зүйд бас нэг хэвшмэл болсон зүйл бол Зөвлөлтийн дипломат ажиллагаа бусад орны дипломат ажиллагаанаас шинжлэх ухаанч байдлаараа эрс ялгаатай хэмээх үзэл юм. Гадаад хэргийн ардын комиссарын газраас эрхлэн гаргадаг “Олон улсын амьдрал” сэтгүүлийн 1923 онд хэвлэгдсэн анхны дугаарт Чичериний бичсэн нийтлэлд: “Зөвлөлтийн дипломат ажиллагааны арга барил нь хуучин дипломат ажиллагаанаас эрс ялгарч байдаг бөгөөд үүгээрээ ч бусад улсын дипломат ажиллагаанаас ялгаатай. Зөвлөлтийн дипломат ажиллагаа түүхийн үйл явцыг Марксист дүн шинжилгээний тусламжтайгаар задлан шинжилж ажилладаг ба энэ ч утгаараа орчин үеийн улс төр, эдийн засгийн харилцааны хөгжлийн гүн гүнзгий, үндсэн хандлагыг нээн илрүүлдэг”¹² хэмээн нотолжээ.

Оросын дипломат ажиллагаанд марксист арга зүйг авчирсан нь гадаад бодлого ба түүний хэрэглүүр болсон дипломат албыг хамгийн үзэл сурталжсан болгох урьдач нөхцөл байсан юм¹³. Эрх баригч намын заавраар үндэсний эрх ашгийг үзэл суртлын зорилтоор солих аюул, бодит боломж нүүрлэж байлаа. Ийм аюул бүр Октябрийн хувьсгалаас өмнө большевик намын голомтод пролетарийн хувьсгалын онол бойжиж байх үед илрэн харагдаж байжээ. Бүр тэр үед ирээдүйн ажилчин-тариачдын улсын гадаад бодлого социалист хувьсгалын зорилттой холбогдох нь тодорхой байв.

Пролетарийн интернационализмын зарчмыг Зөвлөлт Холбоот улсын гадаад бодлогын үндэс болгосноороо В.И.Ленин социалист хувьсгалын онолыг амьдралд хэрэгжүүлэх хөшүүрэг болгосон. Гэвч энэ нь бодит байдалтай зөрчилдсөн зүйл байсан. Учир нь гэвэл Октябрийн хувьсгалын өмнө Орос улс үндсэндээ тариачдын эх орон байв. Тийм ч учраас пролетарийн интернационализмын зарчим гэгч нь нийгмийн энэхүү давхаргын эрх ашгийг

¹⁰ *Октябрьская революция перед судом американских сенаторов. Официальный отчет “Оверменской комиссии” сената, Москва 1990, с.96*

¹¹ *Г.В.Чичерин. Статьи и речи по вопросам международной политики. Издательство социально-экономической литературы. М., 1961, с.276.*

¹² *Ibid, с.238*

¹³ *И.Г.Усачев, К истории Советской дипломатии (1917-1991гг.), МГИМО, Российская дипломатия в свете мирового и исторического опыта: Ученые записки, Москва 1996, с.15*

орхигдуулж байлаа.

Энэ талаар Г.В.Плеханов “Петроградчуудад илгээсэн ил захидал”-даа *“Засаг төр хуучин дэглэмийг сэргээн тогтоохыг үл хүсэгч улс орны бүхий л амьд хүч, өөрөөр хэлбэл нийгмийн бүхий л анги давхарга дээр тулгуурлах ёстой”* гэж анхааруулж байсан юм. Плеханов Лениний хөрөнгөтний-ардчилсан хувьсгалаас социалист хувьсгал руу шилжих большевикуудын эрмэлзлийн тухай “4-р сарын сэдэв”-ийг солиотой зүйл гэж дүгнэсэн байдаг.

Өөрөөр хэлбэл, Лениний гаргаж тавьсан энэхүү томьёолол нь пролетарийн эв нэгдлийн далбаан дор ямар ч үйл ажиллагааг зөвшөөрөхөд хүргэсэн. Тэрчлэн, уг томьёолол өөрийн улс орны нэгэн адил бусад улс оронд хувьсгалын чиг шугамыг дэмжинэ гэсэн дипломат ажиллагааны нэлээд аюултай хандлагыг агуулж байлаа. Нэг улсад ялсан хувьсгал бусад улс орноос өөрийн загварыг дагахыг шаардах ба энэ үйл явц нь тухайн улсын дипломат ажиллагаа, гадаад бодлогод нөлөөлөх нь дамжиггүй.

Лениний томьёолсон бас нэг зарчим бол нийгэм эдийн засгийн ялгаатай тогтолцоотой улс орнууд энх тайвнаар зэрэгцэн орших тухай байлаа. Тэрээр нийгэм эдийн засгийн ялгаатай тогтолцоотой улс орнууд пролетарийн хувьсгал ялсны дараа тодорхой хугацаанд зэрэгцэн оршин тогтнох болно гэж үзэж байсан. “Европын нэгдсэн улсын урианы тухай” гэсэн 1915 оны 8-р сард бичсэн нийтлэлдээ Ленин ялсан пролетаричууд “үлдсэн капиталист ертөнц”-ийн эсрэг зогсож, бусад улсын дарлагдсан ангийн анхаарлыг өөртөө татаж, бослогод уриалан дуудаж, шаардлагатай тохиолдолд мөлжигч анги болон тэдний улсын эсрэг цэргийн хүч хэрэглэж болохыг ч үгүйсгээгүй юм. Нэг үгээр хэлбэл, социалист орны санаачлагаар улс орнуудын хооронд дайн гарч болно гэсэн үг.

Ленин өөрийн санаачилсан Октябрийн хувьсгалын онолоор бол юуны өмнө хөрш Европын орнуудад түгэн дэлгэрэх бөгөөд улмаар дэлхийн хувьсгалд хүргэнэ гэдэгт итгэж байв. Тэрээр 1919 оны 4-р сарын 11-нд *“Бид дэлхий даяар түгэх хувьсгалыг эхлүүлнэ хэмээн амалсан. Тэр хувьсгал маань эхэлчихээд байна... Харин одоо бүх дэлхий даяар капитализмыг ялахад бидэнд хэдхэн сар л үлдээд байна”* гэж мэдэгдэж байв.

Харин 1921 оны 3 сар гэхэд Ленин бусад улс оронд хувьсгалыг өрнүүлэх эрмэлзэл нь бүтэлгүйтэж, дэлхийн хувьсгал нь зогсонги байдалд орсныг хүлээн зөвшөөрөхөөс аргагүйд хүрсэн. Чухам энэ үед энх тайвнаар амьдрах гэсэн томьёолол гарч ирсэн нь цаашдаа “энх тайвнаар зэрэгцэн орших зарчим” болж хувирсан билээ.